



Тогтвортой хөгжлийн тайлан 2024

НэтКапитал Санхүүгийн Групп



Агуулга

Удирдлагын мэндчилгээ	01
Эрхэм зорилго	02
Онцлох үзүүлэлтүүд	04
БОНЗ ба компанийн засаглал	05
Тогтвортой үйл ажиллагаа ба санхүүжилт	08
Тогтвортой хөгжлийн алсын хараа	17



Б. Хуншагай /Гүйцэтгэх захирал/

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн нийт харилцагчид, түншүүд та бүхэндээ 2024 оны тайлангаа танилцуулж буйдаа таатай байна.

2024 онд компанийн нийт актив хөрөнгө 106 хувиар өсөж 271 тэрбум төгрөгт, харилцагчид олгосон зээлийн хэмжээ 102 хувиар өсөж 228 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Бидэнд итгэл хүлээлгэн үйлчилгээ авдаг 100,000 гаруй үнэнч харилцагч, түншүүд болон компанийнхаа төлөө, харилцагч нарынхаа төлөө гэсэн сэтгэл, зүтгэлтэй 595 ажилтнууддаа талархал илэрхийлье.

“Дижитал шилжилтээр манлайлах” эрхэм зорилгын хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж 150000 гаруй харилцагчид хүрч ажилласан байна. Мөн санхүүгийн хүртээмжийг олон улсын стандартад нийцүүлэн харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, дижитал үйлчилгээг сайжруулж International Digital Customer Experience Standard (IDCXS) стандартыг 95.5 хувийн гүйцэтгэлтэйгээр “Excellence” түвшинд стандартын шаардлагыг ханган сертификатаа гардан авч үйл ажиллагаанд нэвтрүүлээ.

Бид 2024 онд Тогтвортой санхүүжилтийг дэмжих үүднээс нийт зээлийн багцын 7.03 % хувийг ногоон зээлийн багцаар бүрдүүлж ажилласан ба нийгмийн хариуцлагын хүрээнд Паралимп 2024 наадмын шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсоноор тусгай хэрэгцээт хүмүүсийн амжилт, тэмцэл, итгэл найдварын бэлгэ тэмдгийг олон нийтэд хүргэж, хүртээмжтэй нийгмийг дэмжихэд хувь нэмрээ оруулав. Европын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн болон 2024 оны олимпын наадмын шууд дамжуулалтыг ивээн тэтгэснээр бид спортын соёлыг түгээн дэлгэрүүлж, хүүхэд, залуучуудыг эрүүл амьдралын хэв маяг, хамтын зорилго, тууштай байдлын үнэ цэнийг ойлгуулахыг зорилоо.

Цаашид бид тогтвортой санхүүжилтийн зорилт, зарчмуудын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ногоон зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн харилцагч бүрд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгохоор зорьж байна.

Хүндэтгэсэн,
“Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хуншагай



Эрхэм зорилго | **Mission**

- Дижитал шилжилтээр манлайлна.




Үнэт зүйл | **Value**

- Эрч хүчтэй байж бусдыг энергижүүлнэ
- Ил тод байж, итгэл даана
- Гал эрмэлзэлтэй байна
- Хурдтай гүйцэтгэл
- Хөгжилтэй байх



Алсын хараа | **Vision**

- Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг нэгтгэсэн харилцагч төвтэй хиймэл оюун ухаанд суурилсан экосистем бүтээх.



Бидний соёл | **Culture**

- Эерэг хандлага
- Эрсдэлд суурилсан сэтгэлгээ
- Мэргэжлийн баг
- Залуу манлайлал
- Тасралтгүй суралцах
- Амжилтад тэмүүлэгч





БОНЗ-ЫН ХӨГЖИЛ

2021

ТоС-ийн 8 зарчмын хүрээнд байгаль орчин нийгмийн бодлогыг анхлан батлав.

2022

Монгол улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийг хангах, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой хөгжлийн зорилгуудыг биелүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор “Тогтвортой санхүүжилтийн бодлого”-ыг шинэчлэн батлав.

2023

БОНЗ-ын үнэлгээ хийх шаардлагатай зээлийг автоматаар таньдаг болов.

Анхны ногоон зээлийн “Чип төсөл” бүтээгдэхүүнийг ТоС холбоотой хамтран зах зээлд гаргав.

2024

БОНЗ-ын хүрээнд эрсдэлийн зэрэглэлээр шууд харах дашбоард бий болгосон.



Олимп

2024 Паралимп ерөнхий
ивээн тэтгэгч.



NETX

Илтгэлийн уралдаан.



IDCXS

Олон улсын дижитал
хэрэглэгчийн туршлагын
стандарт нэвтрүүлсэн.



Тэлэлт

Хот: 2 салбар, Дижитал 3.
Орон нутаг: 1 салбар нээсэн.



Цаас хэмнэлт

Дижитал зээлийг олгосноор
нийт 864000 хуудас цаасыг
хэмнэж ажилласан.

БОНЗ ба компанийн засаглал



СЗХ 2024 онд ББСБ, Даатгал, ХОМК-иудад дахин **компанийн засаглалын** зайны үнэлгээг хийж, хэрэгжилтийн үнэлгээний тайлан гаргасан ба “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК нь 3 дах жилдээ салбартаа үнэлгээгээр тэргүүлэгч топ 5-н нэг болсон.

Кодекс үнэлгээ 2023 - 94.4%
Кодекс үнэлгээ 2024 - 97.2%

Жендерийн тэгш байдал

Нэткапитал санхүүгийн групп нь нийгэмд тулгамдаад буй жендерийн эрх тэгш байдал, ажлын байрны хомсдол зэрэгт хувь нэмрээ оруулж ажиллахыг эрмэлздэг бөгөөд үүний хүрээнд Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэмд тусгасан байдаг ба “Жендерийн тэгш байдлын бодлого”-ыг боловсруулан ажиллаж байна.

Нийт ажилтнуудын (595) хүйсийн харьцаа



Захирал, удирдлагуудын (76) хүйсийн харьцаа



ТУЗ-Н ГИШҮҮДИЙН (7) хүйсийн харьцаа



Нийт харилцагчийн хүйсийн харьцаа



Тогтвортой үйл ажиллагаа ба санхүүжилт

IDCXS стандартын хэрэгжилтээр:

- 2024 онд бид харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, дижитал үйлчилгээг сайжруулах стратегийн хүрээнд International Digital Customer Experience Standard (IDCXS) стандартыг 95.5 хувийн өндөр гүйцэтгэлтэйгээр “Excellence” түвшинд стандартын шаардлагыг ханган сертификатаа гардан авлаа.
- Манай дотоод дижитал процессууд, хэрэглэгчтэй харилцах сувгууд, өгөгдлийн аюулгүй байдал олон улсын жишигт нийцэж, ил тод, найдвартай байдлыг хангах түвшинд хүрсэн.

Мэдээллийн аюулгүй байдал

2023 оны босго дээр Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцооны ISO/IEC 27001:2013 олон улсын стандартыг нэвтрүүлж сертификатаа гардан авч байсан бол 2024 онд дахин баталгаажуулалт хийсэн.

Мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн нууцлалын удирдлагыг сайжруулснаар тогтвортой, үнэмшилтэй дижитал харилцаа бүрдүүлэхэд бодит алхам боллоо. Энэхүү шинэчлэл нь манай компанийн тогтвортой, хэрэглэгч төвтэй хөгжилд чиглэсэн урт хугацааны бодлогын чухал хэсэг юм.





Шинэ салбар - Шинэ модод

Бид байгаль хамгааллын хүрээнд шинэ салбарын нээлтэд зориулж мод тарих уламжлалыг дотооддоо нэвтрүүлэн ажилладаг.

Цаас хэмнэлт ба дахин боловсруулалт

Netpay Апп-аар дамжуулж 2024 онд нийт 351800 хүнд дижитал зээл олгосон.

Нэг зээл бүрд - 10 хуудас бүхий цаас хэмнэдэг нийт - 351800 хуудас цаас хэмнэснээр ойролцоогоор 26.4 тонн нүүрсхүчлийн хий (Co2) байгальд ялгарахаас сэргийлсэн байна.

Ногоон оффис

Байгаль орчинд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулах зорилгынхоо хүрээнд хог хаягдлаа ангилж байна. Ногоон оффис болгох үүднээс хэрэгжүүлэхээр зорьж буй алхмууд:

- Оффисын бичиг хэрэгслийг ногоон худалдан авалтаар солих
- Нийт ажилчдыг тогтвортой санхүүжилттэй холбоотойгоор заавар дүрэм журмын талаар мэдлэг олгох сургалт орж, ногоон оффистой болох дадлыг хэрэгжүүлэн ажиллах

Сургалт, хөгжил

2022 оноос хойших ажилд орсон салбарын ажилчдыг өнгөрөгч 2-р сард ТоС-ын мэргэшүүлсэн сертификат олгох сургалтад хамруулсан.

Ажилтанд зориулсан хөтөлбөрүүд

- Уян хатан ажлын цаг
- Өглөөний цай хөтөлбөр
- Сонирхол дэмжих хөтөлбөрүүд
- Спорт хөтөлбөр/хөнгөлөлт/
 - NC League - Quiz night
 - NetX - NetPodcast
- Холбогдох дүрэм журмууд:
 - Шүгэл үлээх бодлого
 - Ёс зүйн дүрэм





Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

- 2024 онд бид нийгмийн хариуцлагын хүрээнд спорт, соёлын салбар дахь олон улсын чанартай арга хэмжээнүүдийг дэмжин, хүүхэд залуус болон тусгай хэрэгцээт иргэдийн хөгжил, урам зоригт бодит хувь нэмрээ орууллаа.
- Паралимп 2024 наадмын шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр оролцсоноор тусгай хэрэгцээт хүмүүсийн амжилт, тэмцэл, итгэл найдварын бэлгэ тэмдгийг олон нийтэд хүргэж, хүртээмжтэй нийгмийг дэмжихэд хувь нэмрээ оруулав.
- Европын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн болон 2024 оны олимпын наадмын шууд дамжуулалтыг ивээн тэтгэснээр бид спортын соёлыг түгээн дэлгэрүүлж, хүүхэд, залуучуудыг эрүүл амьдралын хэв маяг, хамтын зорилго, тууштай байдлын үнэ цэнийг ойлгуулахыг зорьсон.
- Боловсролыг дэмжих, тэгш боломжоор хангах зорилгын хүрээнд: Компанийн хуучин, бүрэн ажиллагаатай компьютерыг актлахын оронд Ерөнхий боловсролын сургуулиудад хандивлах замаар дижитал боловсролыг дэмжиж, хөдөө орон нутаг болон эмзэг бүлгийн сурагчдад суралцах боломжийг тэлсэн.

Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн тоо: 129,000+

- 2024 онд ирсэн нийт Санал хүсэлтийн тоо – **321**
- 2024 онд ирсэн нийт Гомдлын тоо - **50**
- 2024 онд харилцагчаас ирсэн нийт **50 гомдлыг** “Харилцагчийн дуу хоолойны бодлого”-д заасны дагуу 90-180 минутын дотор шийдвэрлэн, хариу өгч ажилласан.
- 2024 онд харилцагчаас ирсэн санал хүсэлт ба гомдлыг **100%** шийдвэрлэн ажилласан болно.

Гомдлын удирдлага

IDCXS2022 Олон улсын дижитал харилцагчийн туршлагын стандартын дагуу “Харилцагчийн дуу хоолойны бодлого”-ыг боловсруулан 2024 оны 09-сард батлан мөрдөж ажиллаж байна.





Тогтвортой санхүүжилт

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн Тогтвортой санхүүжилтийн бодлого нь Группээс Монгол Улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийг хангах, байгаль орчин, нийгэм, засаглал, тогтвортой хөгжил ба уур амьсгалын зорилгуудыг биелүүлэхэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тогтвортой санхүүжилт хэсэгт дараах чиглэлийн ажлууд багтдаг. Үүнд:


- Зээлийн эх үүсвэр татах
- Ногоон бизнес эрхлэгч, хувь хүмүүст зориулсан ногоон зээл олгох
- Зээлийн хүсэлтүүдэд Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ хийх
- Бичил бизнесийн зээлийг нэмэгдүүлж жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих ажлууд багтана.



Байгууллагын санхүүгийн хүртээмж

NetPay аппликейшнаар дамжуулан нэг удаа гэрээ хийгээд дэлхийн хаанаас ч, хэзээ ч зээл авах боломжтой дижитал бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Нийгэм засаглалын хүрээнд тогтвортой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол улсын 21 аймаг болон 8 дүүрэгт үйл ажиллагаагаа явуулж цэцэрлэг, эмнэлэг, нийтийн аж ахуй, нийгмийн эрүүл мэнд, мод тарих чиглэлээр ажлууд гүйцэтгэж байна.



Ногоон зээлийн багц

Компанийн нийт зээлийн багцын **7.03 хувийг** ногоон зээлийн багц эзэлдэг.

Ногоон зээл

Зээлийн багц

Автомашины зээл /hybrid/	1.7 тэрбум
Чип, монгол гэрийн халаалт, дулаалгын багц	2.3 сая
Дижитал бараа	3.1 тэрбум
Өрхийн зээл	11.4 тэрбум



Тогтвортой хөгжлийн алсын хараа

Тогтвортой хөгжлийн алсын хараа

Групп нь нийгмийн хариуцлагын ажлуудыг жил бүр зохион байгуулж, зохих төсвийг батлан ажилладаг бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх үйл ажиллагаанууд нь тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулдаг үйл ажиллагаанууд байдаг. Бид тогтвортой хөгжлийн алсын хараанд дараах ажлуудыг тусган ажиллаж байна.

Хийгдэх ажлууд

- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Ногоон зээл олголтыг нэмэгдүүлэх
- Жишиг ногоон оффис бий болгох
- Агаарын бохирдлыг бууруулах ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргах гэх мэт

ТОГТВОРТОЙ
БАЙДАЛ



УУР АМЬСГАЛЫН
ЭРСДЭЛ



ЖЕНДЕРИЙН
ЭРХ ТЭГШ
БАЙДАЛ



ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТ



НОГООН
САНХҮҮЖИЛТ



Тогтвортой санхүүжилтийн бодлого ба хийгдэх үйл ажиллагаа

Энэхүү бодлого нь Монгол Улсын Засгийн газраас баримталж буй “Алсын хараа 2050”, “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг 2030” болон “Үндэсний ногоон таксономи” баримт бичгүүдтэй нийцсэн байдаг ба цаашид шаардлагатай хугацаанд шинэчлэн, мөрдөж ажиллана.

Тогтвортой санхүүжилт

- Хариуцлагатай бизнесийг дэмжих
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Зээлийн БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ
- ОУ-ын санхүүгийн байгууллагуудын харилцаа ба санхүүжилт
- ОУ-ын ба дотоодын тогтвортой санхүүжилтийн санаачилгууд

Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт

- Компанийн нийгмийн хариуцлагын стратеги болон сангийн үйл ажиллагаа
- Компанийн нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүд

Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал

- Үйл ажиллагааны, санхүүгийн, Тогтвортой хөгжлийн жилийн тайлангууд
- Хөрөнгө оруулагч, хамтрагч, зохицуулагч байгууллагуудын асуулга, тайлан
- Аудит ба оролцогч талуудын оролцоо

Тогтвортой үйл ажиллагаа

- Хүний нөөцийн бодлого ба тогтвортой ажлын байр
- Компанийн засаглал
- Байгальд ээлтэй ажлын орчин
- Олон талт болон хүртээмжтэй үйл ажиллагаа, үйлчилгээ
- Мэдээллийн аюулгүй байдал ба хяналт шалгалт
- Дотоодын журамд Тогтвортой хөгжлийн зорилгуудыг уялдуулах





ДИЖИТАЛ ШИЛЖИЛТЭЭР МАНЛАЙЛНА